



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2016 оны 9 сарын 28 өдөр

Дугаар А-265

Улаанбаатар хот

“Төлбөрийн системийн хяналтын бодлого”-ыг шинэчлэн батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Төлбөрийн системийн хяналтын бодлого”-ын баримт бичгийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллахыг Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (Э.Анар), тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Ж.Батхуяг)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны А-101 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.БАЯРТСАЙХАН

ТОЛБОРИЙН СИСТЕМИЙН ХЯНАЛТЫН БОДЛОГО

Толборийн системийн хяналт нь толбор тооцооны системд хяналт тавих, үнэлгээ хийх, шаардлагатай үед оорчлолт оруулах замаар толборийн системийн найдвартай, үр ашигтай ажиллагааг хангуулсны үр дүнд үндэсний мөнгөн тэмдэгтэд итгэх олон пийтийн итгэл, санхүүгийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэх зорилготой Тов банкны үүрэг юм.

1. Зорилго

Толборийн системийн хяналтын зорилго нь Үндэсний толборийн систем (ҮТС)-ийн найдвартай, үр ашигтай, тасралтгүй ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг удирдах замаар толборийн системийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалж, санхүүгийн зах зээлийн дэд бүтэц (СЗЗДБ)-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Монголбанк толборийн системд хяналт тавих үүргээ биелүүлэхийн тулд дараах чиглэлийг баримтлан ажиллана. Үүнд:

- 1.1. Толборийн системд учирч болзошгүй системийн эрсдэлээс сэргийлэх, түүнийг үнэлэх, удирдах;
- 1.2. Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалж, системийн аюулгүй байдлыг хангуулан, мөнгө угаах болон луйврын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх;
- 1.3. Оролцогчдын толборийн систем дэх эрх тэгш оролцоог хангах, толборийн үйлчилгээний өрсөлдөөнт зах зээлийн нөхцөлийг бүрдүүлэх;
- 1.4. Толбор тооцооны систем хоорондын харилцан зохицолдоо, нэгдмэл байдлыг хангах;
- 1.5. Бусад эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах.

2. Толборийн системийн хяналтын хамрах хүрээ

Монголбанкнаас өргөн хүрээтэй, эрсдэл ихтэй, саатал хүндрэл нь ҮТС-д нөлөөлөхүйц системийн хувьд нэн чухал болон бусад толбор тооцооны системд хяналт тавина. Дараах үзүүлэлтүүдийг харгалзан үзсэний үндсэн дээр тухайн толбор тооцооны системийг системийн хувьд нэн чухал гэж тооцох эсэхийг шийднэ:

- Гүйлгээний дундаж дүн;
- Гүйлгээний төрөл болон бусад СЗЗДБ-тэй холбогдсон байдал;
- Хэрэглэгчийн тоо.

Монголбанк нь их дүнтэй толбор тооцооны Банкжуулжээ системийг системийн хувьд нэн чухал гэж үзэн, хяналт тавих бөгөөд “Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмууд”-ын дагуу жил бүр үнэлгээ хийнэ.

Монголбанкны хяналт, зохицуулалт нь дараах толбор тооцооны системүүд болон толборийн үйлчилгээ үзүүлэгчийг хамарна:

- 1.1 Төлбөрийн саатал, үйл ажиллагааны тасалдал нь ҮТС-д үлэмж хэмжээний эрсдэл учруулж болох “Их дүнтэй төлбөр тооцооны систем”;
- 1.2 Системийн хувьд нэн чухал биш боловч үйл ажиллагаа нь төлбөрийн систем болон үндэсний мөнгөн тэмдэгтэд итгэх олон нийтийн итгэлд нөлөөлж болзошгүй гэж Монголбанкнаас үзсэн бусад төлбөр тооцооны системүүд;
- 1.3 Төлбөрийн хэрэгсэл гаргагч, шинэ дэвшилтэт төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид;
- 1.4 Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгч, хил дамнасан төлбөр, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг;
- 1.5 Системийн операторуудад гэрээний дагуу нэн чухал үйлчилгээ үзүүлэгчид.

Төлбөрийн системийн хяналт, шалгалтыг дараах хүрээг хамруулан хийнэ:

- Төлбөрийн системийн оролцогч, операторын үйл ажиллагаа;
- Төлбөрийн хэрэгсэл, төлбөр тооцооны үйлчилгээний зөвшөөрөл, дүгнэлт;
- Төлбөр тооцооны системийн техник хангамж, програм хангамж;
- Төлбөр тооцооны системийн найдвартай үйл ажиллагааг баталгаажуулах техникийн тодорхойлолт, гэрээ, дүрэм, журам;
- Системийн тасралтгүй ажиллагааны зохицуулалт буюу онцгой байдлын төлөвлөгөө, нөөц төв, түүний техникийн зохистой үзүүлэлт;
- Шаардлагатай бусад.

Төлбөрийн системийн хяналт нь төлбөр тооцооны системүүдийн өдөр тутмын үйл ажиллагаа болон төлбөрийн системийн оператор, оролцогчдын тогтмол хэвшсэн үйл ажиллагаанд хамаарахгүй.

1. Төлбөрийн системийн хяналтын үйл ажиллагаа

Монголбанк төлбөрийн системийн хяналтыг “Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмууд”-ыг удирдлага болгон энэхүү бодлогын баримт бичгийн хүрээнд хэрэгжүүлнэ. Төлбөрийн системийн хяналтыг хэрэгжүүлэхдээ шаардлагатай мэдээлэл олж авах, хяналт тавих, үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, шаардлагатай өөрчлөлт хийх гэсэн үндсэн үйл ажиллагааг явуулна.

1.1. Шаардлагатай мэдээлэл олж авах

Монголбанк нь оператор болон төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдээс системийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, тайлан (хийгдэж буй төлбөрийн тоо ба дүн, үйл ажиллагааны үзүүлэлтийг тусгасан тоон мэдээлэл)-г тогтмол авна. Эдгээр мэдээллийг нэгтгэн, судалгаа, шинжилгээ хийж, төлбөрийн системийн чиг хандлага, авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг тодорхойлох болон системийн найдвартай, үр ашигтай байдлын үнэлгээг хийхэд ашиглана.

1.2. Хяналт тавих:

Төлбөрийн системийн хяналтыг зохистой, үр ашигтай хэрэгжүүлэхийн тулд оператор болон төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн эрх зүйн баримт, мэдээлэл, статистик үзүүлэлтүүдийг тодорхой давтамжтайгаар цуглуулж, дүрэм, журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавина. Шаардлагатай тохиолдолд газар дээр нь шалгалт хийж үр дүнг системийн найдвартай, үр ашигтай байдлын үнэлгээнд ашиглаж болно.

Төлбөр тооцооны системд хяналт тавьсны үр дүнд Монголбанк системүүдийн ажиллагаа, харилцан нөлөөлөл, бэлэн бус төлбөрийн хэрэгслийн хэрэглээний өөрчлөлтийн талаар мэдэж байх ач холбогдолтой.

1.3. Үнэлгээ хийх:

Төлбөрийн системийн үнэлгээнд Төлбөр тооцооны системийн хороо, Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагын техникийн зөвлөл хамтран гаргасан “СЗЗДБ-ийн ил тод орчин болон үнэлгээний аргачлал”-ыг удирдлага болгох ба төлбөр тооцооны систем бүрээр эрсдэлийг тодорхойлсны үндсэн дээр нарийвчлан үнэлгээ хийх шаардлагатай системийн хэсгийг тодорхойлж, системийн бүтэц, үйл ажиллагааг олон улсын стандартад нийцэж байгаа эсэхийг тогтооно. Энэхүү үнэлгээг хийснээр СЗЗДБ-д учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлон, түүнийг үнэлэх, бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

Монголбанк төлбөр тооцооны системүүдийг үнэлгээний аргачлалын дагуу тогтмол, хуваарийн дагуу эсхүл тухай бүрт үнэлэх бөгөөд үнэлгээгээр илэрсэн зөрчил, дутагдлыг засаж залруулах, холбогдох зарчмуудын хэрэгжилтийг хангуулах талаар зөвлөмж өгч, шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь авч ажиллана. Системийн хувьд нэн чухал төлбөр тооцооны систем өөрийн-үнэлгээг заавал хийх ба Монголбанк уг үнэлгээг шалгана.

Хяналт тавьж буй системийн загвар, үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлага, зохицуулалт, үйлчилгээний түвшинд том хэмжээний өөрчлөлт орсон эсхүл орох тохиолдолд үнэлгээг заавал хийнэ. Аливаа системд өргөн хүрээг хамарсан гэнэтийн саатал гарсан тохиолдолд Монголбанк тус системийн үнэлгээг гэнэтийн байдлаар хийж болно.

Монголбанк нь Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)-ны системд хяналт тавьж, үнэлгээ хийнэ.

1.4. Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх

Монголбанк санхүүгийн тогтвортой байдлыг хангахын тулд төлбөрийн системийн эрсдэлийг тодорхойлж, үнэлж, бууруулах арга хэмжээ авч байх шаардлагатай. Энэ нь санхүүгийн зах зээл, цаашлаад эдийн засгийг бүхэлд нь хамарч болох үр дагавартай учраас системийн эрсдэлийг төлбөрийн системийн хяналтын үндсэн асуудал болгон тавьдаг. Иймээс хяналтын тогтолцоог сайтар зохион байгуулснаар төлбөрийн системийн эрсдэлийг бууруулах ач холбогдолтой юм.

Монголбанк төлбөрийн системд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлж (Хавсралт 1-ийг харна уу), эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой журам, заавар гаргах бөгөөд эдгээрийн биелэлт, үнэлгээний үр дүнд тулгуурлан, төлбөрийн системийн эрсдэлийг хянана. Төлбөрийн системийн оператор болон оролцогч өөрийн эрсдэлийг тодорхойлох, бууруулах тохиромжтой арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлж байх үүрэг хүлээнэ.

1.5. Шаардлагатай өөрчлөлт хийх:

Үнэлгээний үр дүнг үндэслэн тухайн системийн найдвартай, үр ашигтай байдлын түвшинг хангаж байгаа эсэх тухай дүгнэлтийг Монголбанк гаргана. Бодлогын шаардлага, зарчмыг хангаагүй тохиолдолд Монголбанкнаас тухайн системд шаардлагатай өөрчлөлтийг хийлгэх арга хэмжээ авна. Монголбанк нь ҮТС-д шаардлагатай аливаа өөрчлөлтийг хийхэд удирдан манлайлж, хөдөлгөгч хүч болон ажиллана.

2. Хяналтын зарчим, стандарт

Монголбанк төлбөрийн системийн хяналтыг Олон улсын төлбөр тооцооны банкны Төлбөрийн болон зах зээлийн дэд бүтцийн хороо, Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагын техникийн зөвлөл хамтран гаргасан “Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн

зарчмууд”, СЗЗДБ-ийн үйл ажиллагаанд Төв банк, холбогдох эрх бүхий байгууллагын хүлээх үүрэг хариуцлага, Төлбөр тооцооны системийн хорооноос гаргасан Төлбөр тооцооны системд Төв банкнаас тавих хяналт, Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээний ерөнхий зарчмуудын дагуу хэрэгжүүлнэ.

3. Төлбөрийн системийн хяналтын хэрэгсэл

Монголбанк төлбөрийн системийн хяналтыг хэрэгжүүлэхдээ хяналтын дараах хэрэгслийг ашиглаж болно. Үүнд:

1. Оператор болон төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид үйл ажиллагааны зөвшөөрөл олгох, үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журам батлах;
2. Оператор болон төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн удирдлага, зохицуулалт, үйл ажиллагаа, хэрэглэгчтэй холбоотой асуудлаар тушаал, шийдвэр гаргах;
3. Систем, төлбөрийн хэрэгслийн дагаж мөрдвөл зохих стандарт, жишиг үзүүлэлтийг тодорхойлох;
4. Системийн оролцогчидтой гэрээ байгуулж, хамтран ажиллах;
5. Оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, бусад эрх бүхий байгууллага болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах;
6. Мэдээлэл, баримт гаргуулан авах, газар дээр нь шалгалт хийх, арга хэмжээ авах, шалгуулж буй этгээдэд Монголбанкны гаргасан шийдвэрт нийцүүлэн засаж залруулах талаар чиглэл өгөх;
7. Хязгаарлалт хийх эсхүл мөнгөн торгууль ногдуулах, оператор болон төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны зөвшөөрлийг түдгэлзүүлэх эсхүл цуцлах;
8. Системийн үр ашигтай, найдвартай ажиллагааг хангуулахын тулд хийх шаардлагатай өөрчлөлт, шинэчлэлтэй холбоотой зөвлөгөөг системийн операторт өгөх;
9. Хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд олон нийтэд төлбөрийн систем, системийн оператор болон төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой мэдээлэл хийх;
10. Төлбөрийн систем, хэрэгсэл, үйлчилгээнд хийгдэх хөгжил шинэчлэлтэй холбоотой судалгаа, шинжилгээ хийх.

4. Хамтын ажиллагаа

Монголбанк нь Олон улсын төлбөр тооцооны банкны Төлбөр тооцооны системийн хороо, Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагын техникийн зөвлөл хамтран гаргасан “СЗЗДБ-ийн үйл ажиллагаанд Төв банк, холбогдох эрх бүхий байгууллагын хүлээх үүрэг хариуцлага”-д заасны дагуу СЗЗДБ-ийн найдвартай, үр ашигтай байдлыг дэмжин холбогдох эрх бүхий байгууллагатай үндэсний болон олон улсын хэмжээнд хамтран ажиллана.

5. Тайлагнал, ил тод байдал

Монголбанк дараах тайлан, мэдээг олон нийтэд ил тод мэдээлнэ:

- Төлбөр тооцооны системүүд, төлбөрийн хэрэгслийн хэрэглээ, систем болон төлбөрийн хэрэгсэл бүрийн гүйлгээний тоо, дүн зэргийг багтаасан улирал тутмын тайлан;
- Жилийн тоон мэдээ, бодлого болон журмын өөрчлөлт, системийн хандлага, ерөнхий чиглэл зэргийг агуулсан “Төлбөрийн системийн тайлан”;

- Төлбөрийн систем, хэрэгсэл, үйлчилгээтэй холбоотой олон улсад болон үндэсний хэмжээнд хийгдэж буй өөрчлөлт шинэчлэлийн талаарх шинжилгээ судалгааны тайлан.

_____оОо_____

Төлбөрийн системийн эрсдэлүүд

Зээлийн эрсдэл: Төлбөрийн системийн оролцогч нь тухайн үед эсвэл ирээдүйд санхүүгийн үүргээ биелүүлэх боломжгүй болох эрсдэл;

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэл: Төлбөрийн системийн оролцогч нь санхүүгийн үүргээ тухайн үед биелүүлэх боломжгүй ч тодорхой хугацааны дараа биелүүлэх эрсдэл;

Системийн эрсдэл: Төлбөрийн системийн оролцогч аливаа нэг тал өөрийн үүргээ биелүүлэх боломжгүй болсноор системийн бусад оролцогч талуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг алдагдуулах эрсдэл (системийн оролцогч нэг талын дампуурал гинжин нөлөөлөл үүсгэснээр бусад оролцогчдын төлбөр тооцоог саатуулах, цаашилбал бүхэл бүтэн системийн хэвийн үйл ажиллагаа болон санхүүгийн зах зээлийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болно);

Хууль эрх зүйн эрсдэл: Төлбөрийн системийн хууль эрх зүйн орчны тодорхойгүй болон дутмаг байдлын улмаас төлбөрийн систем буюу оролцогч урьдаас төсөөлөөгүй санхүүгийн алдагдалд өртөх эрсдэл;

Үйл ажиллагааны эрсдэл: Техник, програм хангамжийн асуудал, хувь хүний алдаа, гадны халдлага зэргийн улмаас төлбөр тооцооны хэвийн үйл ажиллагаа гэмтэх буюу доголдож санхүүгийн алдагдалд өртөх эрсдэл;

Төлбөр тооцооны эрсдэл: Зээлийн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын, үйл ажиллагааны эрсдэл эсвэл эрсдэлтэй төлбөр тооцооны нөхцөлийн улмаас оролцогч хоорондын төлбөрийн урсгал саатах эрсдэл;

Бизнесийн эрсдэл: Орлого буурах эсхүл зардал өссөнөөс зардал нь орлогоос давж, системийн санхүүгийн байдал доголдох эрсдэл.

_____оОо_____